



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Дүрслэх урлагийн музейн 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

Аудитын код: СНАГ-2024/199/НА-СТА-ТШЗ

<p>Цахим хуудас: www.audit.mn</p> <p>Улаанбаатар хот 2024 он</p>	<p>Санхүү-нийцлийн аудитын газрын захирал, тэргүүлэх аудитор : Ц.Наранчимэг Утас: 261663 Цахим хаяг: naranchimegts@audit.gov.mn</p> <p>Аудитын менежер: Д.Энхдалай Утас: 260512 Цахим хаяг: enkhdalaid@audit.gov.mn</p> <p>Аудитор: М.Ганбаатар Утас: 261885 Цахим хаяг: ganbaatarm@audit.gov.mn</p> <p>Аудитыг гэрээгээр гүйцэтгэсэн: Ди Эй Би Жи Аудит ХХК-ийн захирал Н.Дэлгэрмаа Утас: 976-91910954 Цахим хаяг: dabq.audit@gmail.com</p>
--	--

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг
Бага тойруу-3, Засгийн газрын IV байр
Утас:26-04-37, Факс:51-26-42-30
E-mail: info@audit.gov.mn

2024.02.23 № 07/318

танай _____-ны № _____-т

Хязгаарлалттай дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, 8.4, Төсвийн хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Дүрслэх урлагийн музейн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Дүгнэлтийн үндэслэл хэсэгт дурдсан буруу илэрхийлэл нь материаллаг боловч өргөн тархаагүй гэж үзсэн бөгөөд санхүүгийн тайланд үзүүлэх нөлөөг эс тооцвол Дүрслэх урлагийн музейн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар нийт 29,084.1 мянган төгрөгийн алдаа зөрчил илэрч тогтоосон материаллаг байдлын түвшингээс давсан нь дангаараа буюу эсвэл нийтээрээ санхүүгийн тайланд материаллаг боловч өргөн тархаагүй, санхүүгийн тайлангийн "Үнэн зөв байдал", "Эрх ба үүрэг", "Тохиолдсон байх", "Толилуулга ба тодруулга" гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Асуудлыг онцолсон хэсэг

Дүрслэх урлагийн музей нь соёлын үнэт зүйлийг эрэн сурвалжилж, нээн илрүүлэх, олж авах, үзмэрийг бүртгэн баримтжуулах, музейн бүртгэл мэдээллийн сан бүрдүүлэх, үзүүлэлэг дэглэх, үйлчлэх, гадаад дотоодын үзэсгэлэн, боловсрол, танин мэдэхүйн ажил, сургалт зохион байгуулах, эрдэм шинжилгээ, судалгааны чиглэлээр үйл ажиллагаа явуулсан байна.

Боловсрол, соёл шинжлэх ухааны сайдын 2009 оны 78 дугаар тушаалаар батлагдсан журмын дагуу соёлын өвийг улсын нэгдсэн бүртгэл, мэдээллийн санд бүртгэдэг. Музей нь нийт 6 сан хөмрөг, үзүүлэлийн 10 танхимтай. Тайлант оны байдлаар музейн 10,008 дэсийн 16,808 ширхэг үзмэр "Соёлын өвийн Register" цахим программд бүрэн бүртгэгдсэн байна.

Аудитын гол асуудал

Соёлын сайдын 2022 оны А/312 дугаартай "Түүх, соёлын хосгүй үнэт дурсгалт зүйлийг зөөж тээвэрлэх зөвшөөрөл олгох" тухай тушаал, Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын 2023 оны 568 дугаар тогтоол, Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын 2023 оны А-1/2476 дугаар албан тоотоор ирсэн зөвшөөрлийг үндэслэн, музейн захирлын 2023 оны А/92 дугаар тушаалаар музейн сан хөмрөгийн ерөнхий бүртгэл, Register цахим бүртгэл, байгууллагын түүх соёлын дурсгалт зүйл-үндсэн хөрөнгөнд бүртгэлтэй нийт 168 нэр төрлийн 222 ширхэг 609,785.0 мянган төгрөгийн өртөгтэй үзмэр, эд зүйлсийг Чингис хааны музейд балансаас балансад шилжүүлсэн байна.

Соёлын сайдын "Улсын хэмжээнд музейн камер болон дохиолол хамгааллын системийг шинэчлэх" тухай 2023 оны А/270 тушаалын дагуу 84,974.1 мянган төгрөгийн 19 нэр төрлийн 309 ширхэг дохиолол, гал, усны хамгаалалт бүхий тоног төхөөрөмжийг үнэ төлбөргүй хүлээн авч, үндсэн хөрөнгө дансанд бүртгэсэн байна.

Бусад асуудлын хэсэг

Байгууллагын жилийн гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 1 зорилтын хүрээнд 5 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөснөөс 99.8 хувийн гүйцэтгэлтэй гэж тайлагнасан байна. Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

САНХҮҮ-НИЙЦЛИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

Ц.НАРАНЧИМЭГ



Хоёр. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	106,334,421.00	103,006,476.48
33	АВЛАГА	1,131,672.00	-
335	Бусад авлага	1,131,672.00	-
33510	Байгууллагаас авах авлага	1,131,672.00	-
35	БАРАА МАТЕРИАЛ	105,202,749.00	103,006,476.48
354	Хангамжийн бараа материал	105,202,749.00	103,006,476.48
35410	Бичиг хэргийн материал	15,814,671.00	1,155,191.44
35420	Аж ахуйн материал	44,027,780.00	94,255,545.43
35450	Барилгын засварын материал	3,132,000.00	-
35470	Бусад хангамжийн материал	42,228,298.00	7,595,739.61
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	27,671,904,240.59	27,134,237,696.95
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	27,671,904,240.59	27,134,237,696.95
392	Биет хөрөнгө	27,584,903,540.59	27,047,394,496.95
39201	Барилга, байгууламж	1,014,405,900.00	1,014,405,900.00
39202	Хуримтлагдсан элэгдэл	(285,175,372.32)	(356,469,215.40)
39203	Авто тээврийн хэрэгсэл	7,850,000.00	7,850,000.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	(7,850,000.00)	(7,850,000.00)
39205	Машин, тоног төхөөрөмж (компьютер)	239,064,566.55	298,775,035.76
39206	Хуримтлагдсан элэгдэл	(198,727,458.23)	(131,454,218.06)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	121,226,111.12	135,842,879.52
39208	Хуримтлагдсан элэгдэл	(90,974,638.53)	(89,958,316.87)
39123	Түүх соёлын дурсгалт зүйл	26,773,960,500.00	26,164,175,500.00
39217	Номын фонд	11,123,932.00	12,076,932.00
393	Биет бус хөрөнгө	87,000,700.00	86,843,200.00
39301	Програм хангамж	1,225,000.00	1,225,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	(1,067,500.00)	(1,225,000.00)
39303	Бусад биет бус хөрөнгө	86,843,200.00	86,843,200.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН	27,778,238,661.59	27,237,244,173.43
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	-	-
413	Богино хугацаат өр төлбөр	-	-
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	27,778,238,661.59	27,237,244,173.43
51	Засгийн газрын хувь оролцоо	27,778,238,661.59	27,237,244,173.43
51101	Өмч: -Төрийн өмч	2,372,812,225.00	2,372,812,225.00
512	Хуримтлагдсан үр дүн	(290,734,256.40)	(431,672,008.39)
51210	Өмнөх үеийн үр дүн	(232,244,649.57)	109,322,479.77
51220	Тайлант үеийн үр дүн	(58,489,606.83)	(540,994,488.16)
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	25,696,160,692.99	25,296,103,956.82
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ/ӨМЧИЙН ДҮН	27,778,238,661.59	27,237,244,173.43

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан
 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	712,934,963.00	1,124,787,416.61
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	455,000.00	85,149,131.61
120	Нийтлэг татварын бус орлого	455,000.00	85,149,131.61
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого-Үндсэн хөрөнгө	455,000.00	85,149,131.61
13	Тусламж, санхүүжилтийн орлого	712,479,963.00	1,039,638,285.00
130	Улсын төвлөрсөн төсвөөс	539,116,200.00	814,049,700.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	539,116,200.00	814,049,700.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	173,363,763.00	225,588,585.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	91,772,200.00	102,089,400.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	81,591,563.00	123,499,185.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН (II)	771,092,620.57	1,054,140,233.31
21	УРСГАЛ ЗАРДАЛ	771,092,620.57	1,054,140,233.31
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	723,134,134.88	1,030,683,007.41
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	397,955,490.48	585,582,138.65
210101	Үндсэн цалин	251,716,236.00	323,347,574.14
210102	Нэмэгдэл цалин	81,572,433.90	102,156,824.16
210103	Унаа хоолны хөнгөлөлт	39,713,998.83	63,110,000.00
210104	Урамшуулал	24,952,821.75	96,967,740.35
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	50,758,200.00	73,044,060.05
210201	Тэтгэврийн даатгал	35,194,596.98	49,158,391.15
210202	Тэтгэмжийн даатгал	4,117,596.00	6,095,647.64
210203	ҮОМШӨ-ний даатгал	3,183,048.71	4,872,258.12
210204	Ажилгүйдлийн даатгал	742,393.57	1,212,842.11
210205	Эрүүл мэндийн даатгал	7,520,564.74	11,704,921.03
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	28,577,892.13	36,621,250.87
210301	Гэрэл, цахилгаан	14,375,317.30	18,619,923.74
210302	Түлш, халаалт	11,854,804.83	15,547,304.13
210303	Цэвэр, бохир ус	2,347,770.00	2,454,023.00
2104	Хангамж, бараа материалын зардал	17,070,762.20	40,558,487.56
210401	Бичиг хэрэг	3,396,250.00	17,297,779.56
210402	Тээвэр, шатахуун	2,781,350.00	12,985,780.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	2,423,279.20	2,396,922.00
210405	Хог хаягдал устгах, цэвэрлэх	1,034,564.00	512,800.00
210406	Бага үнэтэй түргэн элэгдэх зүйлс	7,435,319.00	7,365,206.00
2105	Норматив зардал	2,591,900.00	1,045,000.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	2,591,900.00	1,045,000.00
2106	Уд хогшил, урсгал засварын зардал	9,214,830.00	8,626,750.00
210604	Урсгал засвар	9,214,830.00	8,626,750.00

2107	Томилолт, зочны зардал	-	20,872,000.00
210702	Дотоод албан томилолт	-	20,872,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	110,817,203.50	122,764,497.53
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	107,548,391.00	119,312,797.53
210802	Аудит, баталгаажуулалт зэрэглэл тогтоох зардал	2,000,000.00	411,900.00
210803	Даатгалын үйлчилгээний төлбөр	-	47,400.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	44,400.00	21,800.00
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	9,600.00	6,100.00
210806	Мэдээлэл технологийн үйлчилгээний хөлс	751,300.00	2,811,300.00
210807	Газрын төлбөр	421,312.50	153,200.00
210808	Банк санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	42,200.00	-
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	106,147,856.57	141,568,822.75
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	12,297,745.00	54,743,918.96
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	93,850,111.57	86,824,903.79
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	47,958,485.69	23,457,225.90
2132	Бусад урсгал шилжүүлэг	37,913,800.00	21,645,200.00
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	-	21,257,000.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	17,517,400.00	-
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн урамшуулал	19,436,400.00	-
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	960,000.00	388,200.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	10,044,685.69	1,812,025.90
213301	Улсын төсвийн орлогод төвлөрүүлэх шилжүүлэг	8,537,566.65	1,469,464.40
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	1,507,119.04	342,561.50
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	1,507,119.04	342,561.50
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)	(58,157,657.57)	70,647,183.30
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	(331,949.26)	(611,641,671.46)
225001	Үндсэн хөрөнгө худалдсаны гарз	331,949.26	611,641,671.46
5	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V)	(58,489,606.83)	(540,994,488.16)

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)	712,479,963.00	1,039,638,285.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	712,479,963.00	1,039,638,285.00
130	Улсын төвлөрсөн төсвөөс	539,116,200.00	814,049,700.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	539,116,200.00	814,049,700.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	173,363,763.00	225,588,585.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	91,772,200.00	102,089,400.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	81,591,563.00	123,499,185.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (II)	682,541,763.00	963,987,385.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	682,541,763.00	963,987,385.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	672,497,077.31	962,175,359.10
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	397,955,490.48	585,582,138.65
210101	Үндсэн цалин	251,716,236.00	321,583,628.12
210102	Нэмэгдэл цалин	81,572,433.90	102,156,824.16
210103	Унаа хоолны хөнгөлөлт	39,713,998.83	63,110,000.00
210104	Урамшуулал	24,952,821.75	98,731,686.37
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	50,758,200.00	73,044,060.05
210201	Тэтгэврийн даатгал	35,194,596.98	49,158,391.15
210202	Тэтгэмжийн даатгал	4,117,596.00	6,095,647.64
210203	ҮОМШӨ-ний даатгал	3,183,048.71	4,872,258.12
210204	Ажилгүйдлийн даатгал	742,393.57	1,212,842.11
210205	Эрүүл мэндийн даатгал	7,520,564.74	11,704,921.03
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	29,709,564.13	35,489,578.87
210301	Гэрэл, цахилгаан	14,375,317.30	18,619,923.74
210302	Түлш, халаалт	12,824,446.83	14,577,662.13
210303	Цэвэр, бохир ус	2,509,800.00	2,291,993.00
2104	Хангамж, бараа материалын зардал	21,248,051.20	24,947,312.00
210401	Бичиг хэрэг	3,437,550.00	2,490,600.00
210402	Тээвэр, шатахуун	5,126,700.00	12,985,780.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	2,423,279.20	2,396,922.00
210405	Хог хаягдал устгах, цэвэрлэх	1,234,564.00	505,000.00
210406	Бага үнэтэй түргэн элэгдэх зүйлс	9,025,958.00	6,569,010.00
2105	Норматив зардал	2,591,900.00	1,265,000.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	2,591,900.00	1,265,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	10,120,450.00	7,618,700.00
210604	Урсгал засвар	10,120,450.00	7,618,700.00
2107	Томилолт, зочны зардал	-	20,872,000.00
210702	Дотоод албан томилолт	-	20,872,000.00

2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	122,199,621.50	191,711,369.53
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	118,930,809.00	188,259,669.53
210802	Аудит, баталгаажуулалт зэрэглэл тогтоох зардал	2,000,000.00	411,900.00
210803	Даатгалын үйлчилгээний төлбөр	-	47,400.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	44,400.00	21,800.00
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	9,600.00	6,100.00
210806	Мэдээлэл технологийн үйлчилгээний хөлс	751,300.00	2,811,300.00
210807	Газрын төлбөр	421,312.50	153,200.00
210808	Банк санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	42,200.00	-
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	47,958,485.69	23,457,225.90
2132	Бусад урсгал шилжүүлэг	37,913,800.00	21,645,200.00
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	-	21,257,000.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	17,517,400.00	-
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн урамшуулал	19,436,400.00	-
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	960,000.00	388,200.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	8,537,566.65	1,469,464.40
213301	Улсын төсвийн орлогод төвлөрүүлэх шилжүүлэг	8,537,566.65	1,469,464.40
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	1,507,119.04	342,561.50
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	1,507,119.04	342,561.50
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)	29,938,200.00	75,650,900.00
4	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРЛАГЫН ДҮН (IV)	29,938,200.00	75,650,900.00
5	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	29,938,200.00	75,650,900.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	29,938,200.00	75,650,900.00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)	(29,938,200.00)	(75,650,900.00)
7	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	-	-
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	-	-
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	-
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	-

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан үр дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
2021 оны 12-р сарын 31-ээрх үлдэгдэл	2,372,812,225.00	25,709,382,660.67	(245,466,617.25)	27,836,728,268.42
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт			13,221,967.68	13,221,967.68
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	2,372,812,225.00	25,709,382,660.67	(232,244,649.57)	27,849,950,236.10
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт/бууралт		(13,221,967.68)		(13,221,967.68)
Тайлант үеийн үр дүн			(58,489,606.83)	(58,489,606.83)
2022 оны 12-р сарын 31-ээрх үлдэгдэл	2,372,812,225.00	25,696,160,692.99	(290,734,256.40)	27,778,238,661.59
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт			400,056,736.17	400,056,736.17
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	2,372,812,225.00	25,696,160,692.99	109,322,479.77	28,178,295,397.76
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт/бууралт		(400,056,736.17)		(400,056,736.17)
Тайлант үеийн үр дүн			(540,994,488.16)	(540,994,488.16)
2023 оны 12-р сарын 31-ээрх үлдэгдэл	2,372,812,225.00	25,296,103,956.82	(431,672,008.39)	27,237,244,173.43

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан
 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	814,049,700.00	812,580,235.60	1,469,464.40	99.8
УРСГАЛ ЗАРДАЛ	814,049,700.00	812,580,235.60	1,469,464.40	99.8
БАРАА ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	792,404,500.00	790,935,035.60	1,469,464.40	99.8
Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	585,751,100.00	585,582,138.65	168,961.35	100.0
Үндсэн цалин	319,785,800.00	321,583,628.12	(1,797,828.12)	100.6
Нэмэгдэл цалин	100,578,600.00	102,156,824.16	(1,578,224.16)	101.6
Унаа хоолны хөнгөлөлт	70,828,800.00	63,110,000.00	7,718,800.00	89.1
Урамшуулал	94,557,900.00	98,731,686.37	(4,173,786.37)	104.4
Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	73,219,000.00	73,044,060.05	174,939.95	99.8
Тэтгэврийн даатгал	49,788,900.00	49,158,391.15	630,508.85	98.7
Тэтгэмжийн даатгал	5,857,600.00	6,095,647.64	(238,047.64)	104.1
ҮОМШӨ-ний даатгал	4,686,000.00	4,872,258.12	(186,258.12)	104.0
Ажилгүйдлийн даатгал	1,171,500.00	1,212,842.11	(41,342.11)	103.5
Эрүүл мэндийн даатгал	11,715,000.00	11,704,921.03	10,078.97	99.9
Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	18,931,000.00	18,280,869.70	650,130.30	96.6
Гэрэл, цахилгаан	10,346,000.00	10,123,554.33	222,445.67	97.8
Түлш, халаалт	8,008,600.00	6,634,343.37	1,374,256.63	82.8
Цэвэр, бохир ус	576,400.00	1,522,972.00	(946,572.00)	264.2
Хангамж, бараа материалын зардал	2,092,900.00	1,897,567.20	195,332.80	90.7
Бичиг хэрэг	161,600.00	161,000.00	600.00	99.6
Тээвэр, шатахуун	356,100.00	356,100.00	-	100.0
Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	547,900.00	476,137.20	71,762.80	86.9
Хог хаягдал устгах, цэвэрлэх	605,500.00	505,000.00	100,500.00	83.4
Бага үнэтэй түргэн элэгдэх зүйлс	421,800.00	399,330.00	22,470.00	94.7
Норматив зардал	1,270,200.00	1,265,000.00	5,200.00	99.6
Нормын хувцас, зөөлөн эдлэл	1,270,200.00	1,265,000.00	5,200.00	99.6
Эд хогшил, урсгал засварын зардал	57,618,700.00	57,618,700.00	-	100.0
Багаж, техник, хэрэгсэл	20,000,000.00	20,000,000.00	-	100.0
Тавилга	30,000,000.00	30,000,000.00	-	100.0
Урсгал засвар	7,618,700.00	7,618,700.00	-	100.0
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	53,521,600.00	53,246,700.00	274,900.00	99.5
Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	52,486,100.00	52,231,900.00	254,200.00	99.5
Аудит, баталгаажуулалт зэрэглэл тогтоох зардал	411,900.00	411,900.00	-	100.0
Даатгалын үйлчилгээний төлбөр	47,400.00	47,400.00	-	100.0
Тээврийн хэрэгслийн татвар	21,800.00	21,800.00	-	100.0
Тээврийн хэрэгслийн оношилгоо	6,100.00	6,100.00	-	100.0

Мэдээлэл технологийн үйлчилгээний хөлс	374,400.00	374,400.00	-	100.0
Газрын төлбөр	153,200.00	153,200.00	-	100.0
Банк санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	20,700.00	-	20,700.00	-
УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	21,645,200.00	21,645,200.00	-	100.0
Бусад урсгал шилжүүлэг	21,645,200.00	21,645,200.00	-	100.0
Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	21,257,000.00	21,257,000.00	-	100.0
Нэг удаагийн мөнгөн тэтгэмж, урамшуулал	388,200.00	388,200.00	-	100.0
ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	814,049,700.00	812,580,235.60	1,469,464.40	99.8
УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	814,049,700.00	812,580,235.60	1,469,464.40	99.8
Улсын төсвөөс санхүүжих	814,049,700.00	812,580,235.60	1,469,464.40	99.8
Тохируулсан орлогын дүн		-		
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		-		
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		-		
Байгууллагын тоо	1	1		
Ажиллагсдын тоо	32	32		100.0
Удирдах ажилтан	1	1		100.0
Гүйцэтгэх ажилтан	15	15		100.0
Үйлчлэх ажилтан	16	16		100.0
Орон тооны мэдээлэл	32	32		100.0
Соёл урлагийн салбарын төрийн үйлчилгээний албан хаагч (ТҮСУ)	20	20		100.0
Төрийн үйлчилгээний бусад албан хаагч (ТҮ)	10	10		100.0
Гэрээт ажилтан	2	2		100.0

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл
НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН		225,588,585.00
УРСГАЛ ЗАРДАЛ		225,588,585.00
БАРАА ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ		225,588,585.00
Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал		17,208,709.17
Гэрэл, цахилгаан		8,496,369.41
Түлш, халаалт		7,943,318.76
Цэвэр, бохир ус		769,021.00
Хангамж, бараа материалын зардал		23,049,744.80
Бичиг хэрэг		2,329,600.00
Тээвэр, шатахуун		12,629,680.00
Шуудан, холбоо, интернэтийн төлбөр		1,920,784.80
Бага үнэтэй түргэн элэгдэх зүйлс		6,169,680.00
Эд хогшил, урсгал засварын зардал		24,872,900.00
Багаж, техник, хэрэгсэл		24,872,900.00
Томилолт, зочны зардал		20,872,000.00
Дотоод албан томилолт		20,872,000.00
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж		139,242,669.53
Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж		136,805,769.53
Мэдээллийн технологийн үйлчилгээний хөлс		2,436,900.00
Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг		342,561.50
Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, төвлөрүүлэх шилжүүлэг		342,561.50
ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР		225,588,585.00
Нэмэлт санхүүжилтийн орлого		225,588,585.00
Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө		102,089,400.00
Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого		123,499,185.00

Гурав. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 29,084.1 мянган төгрөгийн 3 зөрчил¹ илэрснээс 277.8 мянган төгрөгийн 1 зөрчилд төлбөрийн акт тогтоож, 28,709.2 мянган төгрөгийн 1 зөрчилд албан шаардлага хүргүүлж, 97.1 мянган төгрөгийн 1 зөрчилд зөвлөмж өгсөн.

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Дд	Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс					
				Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
1	Тайлант оны цалингийн зардлыг хувь хүний орлогын албан татварын тайланд 3,139.1 мянган төгрөгийн зөрүүтэй тайлагнаж, 277.8 мянган төгрөгийн татвар суутгаагүй, цалин илүү олгосон байна.	1	277.8	1	277.8				
2	Тайлант оны бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний нийт 6 гүйлгээний 7,837.2 мянга, албан томилолтын зардал 20,872.0 мянган төгрөг, нийт 28,709.2 мянган төгрөгийн гүйлгээний тооцоо бодсон акт, анхан шатны баримтгүй, бүрдэл дутуу баримтаар гүйлгээ хийж бүртгэлд тусгасан, өмнөх зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллаагүй.	1	28,709.2			1	28,709.2		
3	Музейн эзэмшлийн газрыг газрын гэрчилгээнд кадастрын зургийн хэмжээнээс 3.0 м.кв-аар дутуу байна.	1	97.1					1	97.1
Дүн		3	29,084.1	1	277.8	1	28,709.2	1	97.1

Дөрөв. Төсвийн захирагчийн ангиллаар аудитад хамрагдсан байдал ба санал дүгнэлтийн талаарх мэдээллийн нэгтгэл

№	Төсвийн захирагчийн ангилал	Байгууллага, нэгжийн тоо				Санал дүгнэлтийн хэлбэр			
		Аудитад хамрагдах	Үүнээс: Аудит хийсэн хэлбэр			Зөрчилгүй	Хязгаарлалттай	Сөрөг	Дүгнэлт өгөхөөс татгалзсан
			Санал дүгнэлт гаргасан	Түүвэрт хамруулсан	Аудит хийгээгүй				
А	1	2	3	4	5	6	7	8	9
1	ТШЗ	1	1				1		
2	Төсөл, хөтөлбөр								
3	ЗГТС								
4	ТТЗ								
5	ТЕЗ								
НИЙТ		1	1				1		

¹ Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.